

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН МАРГААН ТАСЛАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Маргаан таслах комисст хандах, маргааныг хуралд оруулах, маргааны оролцогч.

- 1.1. Маргаан таслах комисс нь Намын Их Хурлаас сонгогдсон, эсвэл намын их хурлаас эрх олгосны дагуу Төлөөлөгчдийн танхимаас сонгогдсон 15 хүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүдээс нууц санал хураалтаар сонгосон даргатай байна.
- 1.2. Маргаан таслах комисс гурван үндсэн чиглэлээр гомдол хүлээн авч шийдвэрлэнэ.
 - 1.2.1. Гишүүнчлэл, намын гишүүний бүртгэлтэй холбоотой асуудал;
 - 1.2.2. Хурал, хурлын шийдвэр, санал хураалт, дотоод сонгуультай холбоотой асуудал;
 - 1.2.3. Намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал.
- 1.3. Маргаан таслах комисст хандсан бүх гомдлыг Маргаан таслах комиссын дарга auditor1@cup.mn хаягаар хүлээн авч анхан шатны шийдвэр гаргах гурав, давж заалдах шатны шийдвэр гаргах долоон гишүүнийг хуваарилна. Ингэхдээ маргааныг анхан, давж заалдах шатны хуралд бэлтгэж оруулах, хурал даргалах гишүүнийг тухай бүр томилно.¹
- 1.4. Маргаан таслах комиссын анхан шатны болон давж заалдах маргааныг хуралд бэлтгэх үүрэг бүхий гишүүн тус маргаанд хариуцагч болох байгууллага, албан тушаалтан, намын гишүүнд гомдлын хувийг илгээн тайлбар, нотлох баримт ирүүлэх хугацаатай даалгавар өгнө.
- 1.5. Маргаан таслах комиссын хуралд гомдол гаргагч, хариуцагч талууд нотлох баримт, үндэслэлийг өөрсдөө бүрдүүлэх үүрэгтэй.
- 1.6. Анхан, давж заалдах шатны хуралд гомдол гаргагч, хариуцагчийн бичгээр ирүүлсэн материал, зураг, видео бичлэг, аудио бичлэг, хурлын үеэр оролцогч нарын гаргасан мэдээллийг үндэслэн маргааныг хэлэлцэнэ.
- 1.7. Хяналтын шатны хуралд зөвхөн анхан, давж заалдах шатны хурлын бэлтгэл болон хэлэлцүүлгийн явцад цугларсан баримтыг оруулж хэлэлцүүлнэ.
- 1.8. Маргаан таслах комиссын хуралд гэрч дуудаж асуухгүй, нүүрэлдүүлэх, таниулах, хөндлөнгийн шинжилгээ хийлгэх ажиллагаа, үзлэг явуулахгүй бөгөөд гуравдагч этгээдийн өгсөн мэдээлэл, дүгнэлт, баримтыг хэргийн оролцогч бичгээр бүрдүүлэх материалд хавсаргаж болно.
- 1.9. Маргаан таслах комиссын хуралд оролцох намын гишүүн өмгөөлөгч, дохионы хэлний орчуулагч, харааны бэрхшээлтэй үед туслах туслагчийн хамт оролцож болно. Оролцогч өөрийгөө итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөр төлөөлүүлж

болно.

- 1.10. Энэ дүрмийн 1.3-т заасан хугацаа дууссаны дараа маргаан таслах комиссын анхан ба давж заалдах шатны хурлыг тэдгээр хуралд маргааныг бэлтгэх гишүүн товлон зарлана.
- 1.11. Маргаан таслах комиссын хурал зайлшгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд цахимаар хуралдах бөгөөд Маргаан таслах комиссын анхан шатны болон, давж заалдах шатны хурлын линкийг тус хуралд бэлтгэх үүрэг бүхий гишүүн, хяналтын шатны хурлын линкийг Маргаан таслах комиссын дарга намын ерөнхий менежер хандан захиалж, тус линкийг хуралдахаар оноолт таарсан гишүүдэд болон маргааны оролцогч нарт имэйлээр илгээнэ.
- 1.12. Маргааны оролцогч гэж гомдол гаргасан гишүүн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч, олон гишүүн хамтдаа гомдол гаргасан бол тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч, хариуцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарыг хэлнэ.

Хоёр. Маргаан таслах хорооны хурал, шийдвэр

- 2.1 Маргаан таслах комиссын хурал нээлттэй хуралдана. Намын гишүүд хурал үүссэн линкийг намын апп-аас хүлээн авч хуралд ажиглагчаар оролцож болно.
- 2.2 Маргаан таслах комиссын хурал дараах горимоор явагдана:
 - 2.2.1 Анхан болон давж заалдах шатны хурлыг хурал даргалахаар томилогдсон гишүүн, нийт гишүүдийн хурлыг маргаан таслах комиссын дарга нээх
 - 2.2.2 Оролцогч нарын зүгээс маргаан таслах комиссын гишүүдийг татгалзах эсэхийг лавлах
 - 2.2.3 Маргаан таслах комиссын гишүүнийг татгалзсан тохиолдолд хурлыг хойшлуулах.
 - 2.2.4 Маргаан таслах комиссын гишүүнийг татгалзаагүй тохиолдолд хурлыг үргэлжлүүлж гомдол гаргагчийн санал, хүсэлтийг сонсох
 - 2.2.5 Хариуцагчийн санал хүсэлтийг сонсох
 - 2.2.6 Маргаан таслах комиссын хуралд оролцож буй гишүүд оролцогчдоос асуулт асууж хариулт авах.
 - 2.2.7 Маргааны оролцогч нараас хаалтыг үг хэлэх эсэхийг тодруулах. Хаалтын үгийг оролцогч бүх талууд хэлэх эрхтэй байна.
 - 2.2.8 Маргаан таслах комиссын гишүүд зөвлөлдөх өрөөнд хаалттай зөвлөлдөх. Цахим хурлын линк үүсгэхдээ тухайн цахим программд маргаан таслах комиссын гишүүд тусдаа өрөө үүсгэн зөвлөлдөх боломжийг хангасан байна.
 - 2.2.9 Хэлэлцэж буй асуудлаар гомдлын шаардлага “үндэслэлтэй”, “үндэслэлгүй” гэсэн саналаар санал хураалт явуулж гуравны хоёрын саналаар шийдвэр гаргана. Гарсан шийдвэрт үндэслэн Маргаан таслах комиссын дүгнэлт, эсхүл зөвлөмжийг томъёолно.
 - 2.2.10 Маргаан таслах комиссын хурлын дүгнэлт, зөвлөмжийг хуралд оролцогчдод танилцуулах.
- 2.3 Маргаан таслах комиссын хурлын шийдвэрийг хурал даргалагч ажлын гурав хоногт багтаан бичгээр гаргаж, хуралд оролцсон гишүүдээр гарын үсэг зуруулан хуралд оролцогч гишүүнд намын апп-д бүртгэлтэй имэйл хаяг руу, хариуцах намын

байгууллагад албан ёсны имэйл хаяг руу тус тус илгээнэ. Хуралд оролцсон гишүүд цахимаар гарын үсэг зурсныг хүчинтэйд тооцно.

2.4 Намын дотоод сонгуулийн үеэр буюу жил бүрийн гуравдугаар сард Маргаан таслах комисс 80 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр ажиллах ба энэ журмын 1.2.1-1.2.2-т заасан асуудлаар ирсэн гомдлыг түргэвчилсэн горимоор авч хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5 Түргэвчилсэн горимоор хэлэлцэж буй асуудалд хариуцагчийн тайлбар гаргаж өгөх хугацаа 72 цаг байна.

Гурав. Маргаан таслах комиссын үйл ажиллагааны төсөв

3.1 Маргаан таслах комиссын дарга жил бүрийн арваннэгдүгээр сарын 1-ний дотор дараа жилийн үйл ажиллагааны төсвийг төлөвлөж намын санхүүчид хүлээлгэн өгнө.

3.2 Маргаан таслах комиссын төсөвт дараах зардлыг багтааж болно:

3.2.1 Хурлын бэлтгэл хангах урсгал зардал

3.2.2 Хагас цагаар ажиллах цагийн урамшуулал

3.2.3 Сонгуулийн үеэр бүтэн ба илүү цаг ажиллах цагийн урамшуулал, өдрийн зардал (per diem);

3.2.4 Сонгуулийн үеэр ажиллах шуурхай ажлын өрөө болон тоног төхөөрөмжийн түрээсийн зардал;

3.2.5 Маргаан таслах комиссын гишүүдийн хэрэглэх оффисын программ хангамжийн лицензийн төлбөр;

3.3 Маргаан таслах комиссын үйл ажиллагааны төсвийг тус комиссын саналд үндэслэн Төлөөлөгчдийн Танхим батална.

3.4 Маргаан таслах комиссын үйл ажиллагааны бодит зардал батлагдсан төсвөөс хэтрэх нөхцөл үүссэн тохиолдолд нэмэлт санхүүжилт хүссэн Маргаан таслах комиссын бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж гаргасан хүсэлтийг маргаан таслах комиссын дарга намын ерөнхий менежерт гаргана.

3.5 Энэ журмын 3.4-т заасан хүсэлтийг хүлээж аваад намын ерөнхий менежер дараах үйл ажиллагааны аль нэгийг гүйцэтгэнэ:

3.5.1 нэмэлт санхүүжилтийг тухайн жилийн намын батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүйгээр олгох;

3.5.2 дараа оны төсөвт нэмж суулган нөхөж өгөх;

3.5.3 намын төсөвт тодотгол хийлгэхээр Төлөөлөгчдийн танхимд оруулахыг хүсэж Намын даргад уламжлах.

3.6 Маргаан таслах комисс нь тусдаа дансгүй байна. Маргаан таслах комиссын төсвийг намын ерөнхий менежер намын данснаас Маргаан таслах комиссын даргын зөвшөөрлөөр зарцуулна.

3.7 Маргаан таслах комисс үйл ажиллагаагаа Намын их хуралд тайлагнана.

3.8 Маргаан таслах комиссын санхүүгийн тайланг намын нэгдсэн санхүүгийн тайланд намын санхүүч нэгтгэнэ.